



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 4 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

1. ХУРЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хурал зарласан огноо: 2023/03/17

Хурлын төрөл: Ээлжит

Хурлын хэлбэр: live-р дамжуулан хуралдав.

Хурал болсон огноо, цаг: 2023.04.28-ны өдрийн 11:00 цагт

Хурал болсон газар: МИК-ийн байранд

Хурлын дарга: Чулуундоржийн Хашчулуун

Хуралд оролцсон хувьцаа

эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн овог	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Хувьцаа эзэмшигчийн регистер	Энгийн хувьцааны тоо ширхэг
1		Азиа дайверсифайд Рийл Эстэйт Фанд Нэг хувийн ХОС ХХК	6217125	2,312,500
2		МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК ХХК	5461626	3,081,955
3		ХХ БАНК	2635534	2,070,932
4		ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	5479932	1,232,785
5		ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК	5251494**	1,097,953
6		ГОЛОМТ БАНК ХХК	2075377	1,023,699
7		СИ ЭН БИ КОНСАЛТИНГ	6466257	2,608,480
8		ТӨРИЙН БАНК ХХК	5341469	486,951
9		КАПИТРОН БАНК ХХК	2677377	210,631
10		ХАС БАНК	2578697	210,621
11	ГАНТӨМӨР	ДЭЛГЭРМӨРӨН	ЧВ81100164	81
12	ТҮВШИНЖАРГАЛ	АМГАЛАНБААТАР	АЮ92052313	1
13	ХҮРЭЛ	МАРГАД-ЭРДЭНЭ	ЛЮ87072239	1
14	ЛҮҮРЭВ	ӨНӨРЖАРГАЛ	ЦЖ55100415	1
15	ЖАДАМБА	ЭНХТУНГАЛАГ	ЧГ58100561	1

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;
3. ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
5. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай.

Хуралд оролцсон албан тушаалтан:

1. Б.Гантулга, Гүйцэтгэх захирал;
2. Х.Маралмаа, ТУЗ-ийн ажлын албаны хуульч;

Тооллогын комисс:

3. Б.Болортуяа, “МИК ОССК” ХХК-ийн Хянан нийцүүлэлтийн газрын захирал;
4. Н.Эрдэнэчимэг, “МИК ОССК” ХХК-ийн Санхүү, удирдлагын газрын Төлбөр тооцооны хэлтсийн захирал.
5. Д.Ганчимэг, Эрнст энд Янг Аудит Монголия ХХК-ийн ахлах менежер

Хурлын ирц:

94.03 хувь

ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ

Ч. Хашчулуун

Д.Эрдэнэчимэг:

Ч.Хашчулуун:

“МИК Холдинг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисс хурлын ирцийг танилцуулна уу. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 28-ний өдрийн ээлжит хуралд урьдчилан бичгээр болон цахимаар 14,336,592 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 15 хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа ирүүлсэн нь нийт саналын эрх бүхий 15,246,891 энгийн хувьцаа эзэмшигчдийн 94.03%-ийн ирцтэй байгаа нь хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг хүчин төгөлдөр гэж үзлээ.

Сайн байцгаана уу, “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 94.03 хувийн ирцтэйгээр эхэлж байна. “МИК Холдинг” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 23/08 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тогтоолын дагуу тус хурал эхлэхэд бэлэн боллоо. “Ковид-19” цар тахал дууссан хэдий ч, түүний нөлөөллөөс үүдэлтэй Монгол Улс болон дэлхий эдийн засагт тээвэр логистикийн хямрал, гео улс төрийн нөхцөл байдал, бараа бүтээгдэхүүний хомсдол, үйлдвэрлэлийн тасалдал зэрэг асуудлууд өнгөрсөн 2022 онд нүүрлэсэн жил байлаа. МИК групп компанийн хувьд сүүлийн жилүүдэд компанийн засаглалыг сайжруулахыг тасралтгүй хичээж, Олон улсын санхүүгийн корпорацаас өгсөн зөвлөмжийн дагуу ажиллаж, компани өөрийн засаглалаа олон улсын түвшинд хүргэх, улмаар дэлхийн хэмжээний хөрөнгө оруулагчийг татаж оруулахаар ажиллаж байна. Тайлант онд орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд нийт 661,3 тэрбум төгрөгийн Ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргасан байна. Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулсантай холбоотой давхардсан тоогоор 10 их наяд төгрөгийн зээлийн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр 32 сараар хойшлуулах арга хэмжээг авч ажиллаж, ипотекийн зээлийг “Ковид-19” цар тахлын хүнд үед нэг өдрөөр тасалдуулахгүйн тулд бүх хүч, нөөцөө дайчлан ажиллалаа. Ирэх жилүүдэд ипотекийн хүрээг нэмэгдүүлж, “Ковид-19” цар тахлаас өмнөх түвшинд хүргэх, ногоон барилгыг түлхүү санхүүжүүлж, ногоон бонд босгох замаар ипотекийн ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхээр төлөвлөж байна. Мөн тогтвортой хөгжлийн зорилгуудыг идэвхтэй дэмжин ажиллаж, нийгмийн хариуцлагын хүрээнд олон ажил хийхээр төлөвлөн ажиллаж байна. Хэлэлцэх асуудлын дагуу өнөөдрийн хуралд компанийн 2022 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийсэн “Эрнэст энд Янг Аудит Монголиа” ХХК оролцож байна. Та бүхэн асууж тодруулах зүйл байвал аудитын компаниас асуух боломжтой. Хэлэлцэх асуудлыг дарааллын Б.Гантулга захирлыг урьж байна.

1 дүгээр асуудал:

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;

Б.Гантулга:

Хувьцаа эзэмшигчид та бүрэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргүүлсэн материалын дагуу жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх тайланг танилцуулав.

Ч.Хашчулуун:

Б.Гантулга захиралд баярлалаа. 2022 оны санхүүгийн тайланг “Эрнэст энд Янг Аудит Монголиа” ХХК-ийн ахлах менежер Д.Ганчимэг танилцуулна. Таныг урьж байна.

Д.Ганчимэг:

Сайн байцгаана уу, Манай аудитын компани нь “МИК Холдинг” ХК болон түүний охин компаниудад 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан, ашиг алдагдал, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, бусад тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ. Бидний дүгнэлтээр дээр дурдсан тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, нягтлан бодох бүртгэл нь санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан гэсэн дүгнэлтийг гаргасан. Бид энэхүү аудитын ажлыг олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Мөн нягтлан бодогчдын ёс зүй олон улсын стандартын зөвлөлөөс баталсан мэргэшсэн нягтлан бодогчдын дүрмийн дагуу группээс хараат бус бөгөөд хууль дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад үүрээ бүрэн биелүүлсэн болно. Аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын дүгнэлт хангалттай

Ч.Хашчулуун:

зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна. Аудитын дүгнэлтийг 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр компанид хүргүүлсэн. Баярлалаа. 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаар танилцаад Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангаар танилцаад дараах дүгнэлтийг гаргасан. “МИК Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, дугаар №23/10, 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр, Улаанбаатар хот, Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.7.15 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг тус үндэслэн тогтоох нь : 1. “Эрнст энд Янг Монголиа Аудит” ХХК-ийн гаргасан 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй. 2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй. 3. Энэ тогтоолын 2-т заасан санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэн байгууллагад хүргүүлэн хувьцаа эзэмшигч болон олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн ажлын алба (Г.Саруул)-нд үүрэг болгосугай. 4. Энэ тогтоолын 2-т заасан тайлангуудыг ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн хамт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж зохих шийдвэр гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч (Ч.Хашчулуун)-д даалгасугай. 5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба (Г.Саруул)-д үүрэг болгосугай. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч Ч.Хашчулуун.

2 дугаар асуудал

Ч.Хашчулуун:

Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 23/05 дугаартай тогтоолоор компани нь 2023 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Үндэслэл нь Монгол Улсын Засгийн газраас “Ковид-19” цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор ипотекийн зээлдэгчдийн зээлийн төлбөрийг 2020 оны 2-р сараас эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хойшлуулснаар Групп компанийн орлого 80 хувиар буурсан ба 2022 оны жилийн эцсийн байдлаар хуримтлагдсан алдагдал 641.1 сая төгрөг байна. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөний дагуу бизнес загвар болон үйл ажиллагаанд нөлөөлөх бизнесийн орчны хүчин зүйлст тулгуурлан бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын сайн туршлагын дагуу хөгжүүлж орон сууцны санхүүжилтийг тогтвортой нэмэгдүүлэх, үндсэн чадавхдаа тулгуурлан бизнесийг төрөлжүүлэх дунд хугацааны зорилттой байна. Энэхүү зорилтын хүрээнд “Ковид-19” цар тахлын сөрөг нөлөөллийн улмаас өмнө жилүүдэд хүлээсэн алдагдлыг бууруулж, компанийн санхүүгийн чадавхийг тогтворжуулах шаардлагатай. “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК нь 2021 онд 250 сая ам.долларын бонд гаргасан бөгөөд “Бондын нөхцөлийн гэрээ”-нд 4.7 -д заасны дагуу ногдол ашиг хуваарилахыг хязгаарласан байна.

3 дугаар асуудал:

Ч.Хашчулуун:

ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;

2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргүүлсэн материалын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны тайланг танилцуулав.

4 дүгээр асуудал:

Ч.Хашчулуун:

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

МИК Групп компани нь орон сууцны санхүүжилтийн тасралтгүй байдлыг хангах замаар ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх эрхэм зорилгын хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. “МИК Холдинг” ХК нь компанийн үйл ажиллагааны чиглэлд “Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа явуулах” чиглэлийг нэмэлтээр оруулж тусгай зөвшөөрөл авснаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлд хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа явуулах боломжтой байна. Иймд

компани нь үйл ажиллагааны чиглэлд нэмэлт оруулснаар эрхэм зорилгоо биелүүлэхийн зэрэгцээ ашгийн төлөө хуулийн этгээдийн хувьд бизнесийн үйл ажиллагааг төрөлжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна. Иймд Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа” гэж 4.1.7 дахь заалтаар нэмж оруулахаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

5 дугаар асуудал:

Ч.Хашчулуун:

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоодог. ТУЗ-ийн гишүүнд олгох цалин нь суурь болон нэмэгдэл цалингаас бүрдэнэ. Суурь цалин нь ТУЗ-ийн гишүүнээс томилогдон ажиллаж байгаагийн хувьд сар бүр олгогдох тогтмол цалин бөгөөд нэмэгдэл цалинг хуралд оролцсон оролцоо тус бүрээр тооцон улиралд нэг удаа олгодог. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны хурлаас “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг хэлэлцэж өмнөх жилтэй ижил дүнтэй байхаар дүгнэлт гаргасан. Хурлын дэгийн дагуу Хувьцаа эзэмшигч та бүхнээс хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт байвал бидэнд хурлын програмаар дамжуулан асуугаарай. Та бүхэнд асуулт байвал хариулахад бид бэлэн байна.

Ч.Хашчулуун:

Асуултын хугацаа дууссан байна. Хувьцаа эзэмшигчдээс асуулт ирээгүй тул хурлын дэгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслийг уншиж танилцуулъя. “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Дугаар №23/01, Улаанбаатар хот, Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 23/10 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн тогтоох нь: 1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга Ч.Хашчулуун.

“МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Дугаар №23/02, Улаанбаатар хот, Компанийн дүрмд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь: 1. Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа” гэж 4.1.7 дахь заалтаар нэмж оруулсугай. 2. Энэ тогтоолын 1-т зааснаар шийдвэрлэсэнтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, улсын бүртгэлд бүртгүүлэх болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай. 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ч.Хашчулуун)-д даалгасугай.

“МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Дугаар №23/03, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.12 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 2 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн тогтоох нь: 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2023 оны 5 дугаар 01-ний өдрөөс 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг энэ тогтоолын Хавсралтаар баталсугай. 2. Энэ тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч (Ч.Хашчулуун)-д даалгасугай. Хурлын дэгийн дагуу санал хураалтын хэсэг эхэллээ.

Ч.Хашчулуун:
Н.Эрдэнэчимэг:

Санал хураалт явагдаж дууслаа. Асуулт тус бүрээр санал хураалтын үр дүнг танилцуулахыг тооллогын комиссоос хүсэж байна. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай” асуудалд нийт 14,336,511 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 94.029%-ийн ирцтэй оролцсон бөгөөд ирүүлсэн санал хураалтын нэгдсэн дүнгээр зөвшөөрсөн 14,336,511 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 100%, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 0.00%, татгалзсан 0 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 0.00%-ийн тус тус саналыг өгснийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлсүгэй. “Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн дэх хэсэгт “Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа” гэж 4.1.7 дахь заалтаар нэмж оруулах” асуудалд нийт 14,336,592 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 94.03%-ийн ирцтэй оролцсон бөгөөд ирүүлсэн санал хураалтын нэгдсэн дүнгээр зөвшөөрсөн 14,336,591 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 99.99%, түдгэлзсэн 1 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 0.00001%, татгалзсан 0 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 0.00%-ийн тус тус саналыг өгснийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлсүгэй. “ТУЗ-ын гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай” асуудалд нийт 14,336,592 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 94.03%-ийн ирцтэй оролцсон бөгөөд ирүүлсэн санал хураалтын нэгдсэн дүнгээр зөвшөөрсөн 14,336,592 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 100%, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 0.00%, татгалзсан 0 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 0.00%-ийн тус тус саналыг өгснийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлсүгэй.

Ч.Хашчулуун:

Тооллогын комисст баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлагдсан тогтоолыг танилцуулъя. “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Дугаар№23/01, Улаанбаатар хот, Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 23/10 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн тогтоох нь: 1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга Ч.Хашчулуун. “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Дугаар№23/02, Улаанбаатар хот, Компанийн дүрэмд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь: 1. Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа” гэж 4.1.7 дахь заалтаар нэмж оруулсугай. 2. Энэ тогтоолын 1-т зааснаар шийдвэрлэсэнтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, улсын бүртгэлд бүртгүүлэх болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай. 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ч.Хашчулуун)-д даалгасугай. “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Дугаар№23/03, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.12 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 2 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн тогтоох нь: 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2023 оны 5 дугаар 01-ний өдрөөс 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг энэ тогтоолын Хавсралтаар баталсугай. 2. Энэ тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч (Ч.Хашчулуун)-д

даалгасугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулж, материалыг бэлдсэн Гүйцэтгэх захирал Б.Гантулга, удирдлагын баг болон Эрнст энд Янг Аудит Монголия ХХК-д талархал илэрхийлье. Хурал үүгээр дууслаа.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.САРУУЛ



ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
Ч.ХАШЧУЛУУН

G. Saruul

Ch. Hashchuluun